

**МОНГОЛ УЛСАД ИРГЭНИЙ ХЭРГИЙН ШҮҮХИЙН ШИЙДВЭР  
ГҮЙЦЭТГЭХ АЖИЛЛАГААНЫ ОЙЛГОЛТЫГ ХУУЛЬД ТУСГАСАН  
БАЙДАЛ**

**"THE CONCEPT OF CIVIL COURT DECISION ENFORCEMENT  
PROCEEDINGS IN THE LEGISLATION OF MONGOLIA"**



**С.Бямба-Эрдэнэ**

*Их засаг Олон Улсын их сургуулийн докторант,  
Дотоод хэргийн их сургуулийн Эрх зүй, нийгмийн ухааны  
сургуулийн Хувийн эрх зүйн тэнхимийн багш, ахлах  
дэслэгч*

ORCID ID: 0009-0005-6434-4181

**Хураангуй:** Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа гадаадын иргэн, Монгол Улсын иргэн бүрд хувийн нийтлэг хүсэл зориг байх бөгөөд энэ нь иргэний эрх зүйн эдийн болон эдийн бус баялгийн эрхтэй холбогддог. Иргэний эрх зүйн эд баялгийн эрхийн хүрээнд иргэний зөрчигдсөн эрхийг шүүхээр хамгаалуулах нөхцөл боломжийг шүүх эрх мэдлийн төрийн байгууллага олгодог. Шударга шүүхээс иргэний зөрчигдсөн эрхийг сэргээж, эрх ашгийг нь хамгаалсан шүүхийн шийдвэр гаргасан ч буруутай этгээд шүүхийн шийдвэрийг сайн дураар биелүүлэхгүй байх нь цөөнгүй байдаг. Хуулийн хүчин төгөлдөр болсон шүүхийн шийдвэрийг сайн дураар биелүүлэхгүй тохиолдолд шүүхийн шийдвэр заавал биелэгдэх зарчмын дагуу хууль зааснаар албадан гүйцэтгэж төлбөрийг гаргуулдаг. Энэхүү өгүүллээрээ дамжуулан судлаачийн зүгээс уншигч та бүхэндээ иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг материаллаг болон процессын эрх зүйн хүрээнд тайлбарлаж, холбогдох хууль тогтоомжуудад шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хэрхэн тусгасан талаар танилцуулах болно.

**Түлхүүр үг:** Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа, нэхэмжлэл, иргэний хариуцлага, шүүхийн шийдвэр шийдвэр албадан гүйцэтгэх;

**Abstract:** Every foreign citizen lawfully residing in Mongolia, as well as every Mongolian citizen, possesses individual and common private interests, which are linked to proprietary and non-proprietary rights under civil law. Within the realm of civil property rights, the judiciary—an institution of state power—provides the opportunity to protect violated rights through legal proceedings. Although courts may issue decisions

to restore and protect the rights and interests of individuals, it is not uncommon for the liable party to fail to voluntarily comply with the court's decision. When a legally binding court decision is not voluntarily executed, it is enforced compulsorily in accordance with the law, based on the principle that court decisions must be implemented. Through this article, the researcher aims to explain the enforcement proceedings of civil court decisions within the material and procedural legal framework and to present how these enforcement procedures are reflected in the relevant legislation.

**Keywords:** Civil case adjudication procedure, claim, civil liability, court decision, enforcement of court decision;

### ҮНДСЭН ХЭСЭГ:

Салбар эрх зүйн бүрдлийг хангасан эрх зүйн хэм хэмжээнүүдийг гол төлөв, зорилго, чиг үүргийг нь шалгуур болгож материаллаг болон процессын эрх зүй хэмээн ангилдаг (О.Амархүү, 2018, хууд. 94).

Материаллаг эрх зүйд бидний нийгмийн харилцааг зохицуулж байдаг голлох шинжтэй хүний эрх чөлөөг тунхаглан зааж ардчиллын үнэт зүйлийг бэхжүүлэн хамгаалсан Монгол Улсын Үндсэн хууль, цаашид Үндсэн хуулийн эрх зүй, түүнд нийцүүлэн гаргасан Монгол Улсын Иргэний хууль, Захиргааны ерөнхий хууль, Эрүүгийн хууль буюу иргэн, эрүү, захиргааны эрх зүй гэх мэт том салбар эрх зүй болон бусад дагалдах эрх зүйг хамааруулан дурдаж болно. Харин процессын эрх зүйд дээр дурдсан материаллаг эрх зүйд хамаарах Үндсэн хуулийн эрх зүй, захиргаа, иргэн, эрүүгийн эрх зүйн хэм хэмжээнүүдийн хэрэгжилтийг хангахад чиглэсэн эрх зүйг хамааруулан ойлгож болно. Тухайлбал,

Үндсэн хууль, эрүү, захиргаа, иргэний процессын эрх зүй бүр тухайн салбарт хамаарах материаллаг эрх зүйн маргааныг шийдвэрлэхэд чиглэсэн агуулгатай байдаг. Материаллаг эрх зүйн хэрэгжилтийг хангахын тулд процессын эрх зүйг хэрэгжүүлэх шаардлага урган гарах бөгөөд бид үүнийг төрийн эрх мэдэл хуваарилах онолын нэг хэсэг болсон шүүх эрх мэдлийн хүрээнд тайлбарлах болно.

О.Амархүү бүтээлдээ “Эрх зүйн салбарт ангилагдсан хэм хэмжээ чухам хэний эрх ашиг сонирхлыг хангаж, хамгаалахад чиглэгдсэнийг үндэслэн эрх зүйг нийтийн болон хувийн эрх зүйн гэж төрөлжүүлдэг. Ингэж төрөлжүүлэх нь эрх зүйн хэм хэмжээний агуулгыг илэрхийлнэ. Тэрхүү агуулга нь эрх зүй нийтийн ч хувийн ч аль алиных нь эрх ашиг сонирхлыг хангаж хамгаалдаг гэсэн үг юм” (О.Амархүү, 2018, хууд. 95) гэжээ.

“Хууль зүйн хариуцлагын нэг төрөл болж хөгжиж ирсэн “иргэний эрх зүйн хариуцлага нь иргэний эрх зүйн албадлагаар дамжин бодит илэрлээ олж эрх зүйн харилцаанд оролцогчдын зөрчигдсөн эрхийг сэргээх цогц арга хэмжээ болно. Иргэний эрх зүйн хариуцлагыг үүсэх үндэслэлээр нь гэрээний болон гэрээний бус хариуцлага” (О.Отгонтуяа & О.Амарсанаа, 2022, хууд. 159) гэж ангилна.

Нэрт эрдэмтэн С.Нарангэрэл бүтээлдээ “Иргэний эрх зүйн хариуцлага (англи. Civil legal responsibility) – хууль зүйн хариуцлагын нэгэн төрөл, бусдын иргэний субъектив эрхийг зөрчсөнтэй холбогдсон, иргэний эрх зүйд заасан үүргийг биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүйгээс үүсэх иргэний эрх зүйн хэм хэмжээгээр тогтоосон хууль зүйн үр дагавар. Иргэний эрх зүйн хариуцлагын хэлбэр нь гэрээний буюу гэрээний бус үүргийг биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүйн улмаас хохирлыг нөхөн төлүүлэх, анз (торгууль, алданги) төлөх, зөрчигдсөн эрхийг сэргээн тогтоох, гэм хорыг арилгах зэргээр илэрнэ” (С.Нарангэрэл, 2021, хууд. 190) гэжээ.

Доктор О.Отгонтуяа бүтээлдээ “Иргэний эрх зүйн хариуцлага гэдэг нь иргэний эрх зүйн зөрчил гаргагчаас хохирогчид учруулсан хохирол, гэм хорыг нөхөн төлүүлэх буюу хохирогчийн иргэний зөрчигдсөн эрхийг нөхөн сэргээхэд чиглэсэн цээрлэлийг шүүхээс оногдуулах замаар төрийн албадлага хэрэглэж буй нэг хэлбэрийг хэлнэ” (О.Отгонтуяа & О.Амарсанаа, 2022, хууд. 158) гэж бичжээ.

Зөрчигдсөн эрхийг сэргээхэд чиглэсэн шүүхээс оногдуулсан цээрлэл гэдэг бол иргэний хэргийн шүүхээс зохигч нарт үүрэг болгосон захирамжилсан шинжтэй эрх зүйн акт болохынхоо хувьд шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсон бол нэн даруй биелэгдэх шинжийг агуулж байгааг ойлгоно.

Материаллаг эрх зүйн хүрээнд үүссэн эд баялагтай холбоотой иргэний зөрчигдсөн эрхийг хамгаалахад процессын эрх зүйн иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүйг хэрэгжүүлэх гол субъект болох иргэний хэргийн шүүх, шүүгчийн үйл ажиллагаа нь зөрчигдсөн эрхээ сэргээлгэх хүсэлтэй эрх зүйн харилцаанд оролцогч иргэн, хуулийн этгээдтэй зөвшилцөх замаар зөвхөн нэхэмжлэгчийн хүсэлтээр иргэний хэрэг үүсгэж хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж, иргэний эрх зүйн хариуцлагыг хариуцагчид хүлээлгэж байгаа нь хувийн эрх зүйн салбарт хамаарч байгааг энд дурдах нь зүйн хэрэг юм. Тухайлбал,

Монгол Улсад үйл ажиллагаагаа тасралтгүй явуулж байгаа иргэний хэргийн анхан шатны шүүхүүд дараах 4 төрлийн үндэслэлээр иргэний хэрэг үүсгэдэг (эмхэтгэл, 2002).

1. “Эдийн ба эдийн бус баялагтай холбоотой эрх нь зөрчигдсөн тухай эрх зүйн харилцаанд оролцогч этгээдээс гаргасан нэхэмжлэл” (эмхэтгэл, 2002).
2. “Бусдын эрх, эрх чөлөө, ашиг сонирхлыг хамгаалж шүүхэд мэдүүлэх эрх нь хуулиар олгогдсон этгээдээс гаргасан нэхэмжлэл” (эмхэтгэл, 2002).
3. “Онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлүүлэхээр хуульд заасан асуудлаар сонирхогч этгээдээс гаргасан хүсэлт” (эмхэтгэл, 2002).
4. Захиргааны /Нийтийн ашиг сонирхлыг илэрхийлэн захирамжилсан шийдвэр гаргадаг дараах нийтийн эрх зүйн этгээдийг захиргааны байгууллага гэж ойлгоно/ (Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2015) байгууллагаас

бусад байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаа болон тэдгээрийн гаргасан захиргааны актын талаар гаргасан гомдолд үндэслэн иргэн хэрэг үүсгэдэг. Үүнд:

- “Төрийн гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлдэг төв, орон нутгийн бүх байгууллага” (Эмхэтгэл, 2015).
- “Хууль тогтоомжийг биелүүлж, захирамжилсан шийдвэр гаргадаг Засгийн газрын бус бие даасан агентлаг, түүнтэй адилтгах нийтийн эрх зүйн бусад байгууллага” (Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2015).
- “Захиргааны чиг үүргийг хууль болон нийтийн эрх зүйн гэрээний үндсэн дээр шилжүүлэн авсан этгээд (Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2015).
- “Үйлчилгээг нь нийтээс заавал хэрэглэдэг төрийн ба холимог өмчийн сургууль, эмнэлэг, хэвлэл мэдээлэл, харилцаа холбоо, тээвэр, эрчим хүчний зэрэг байгууллагын захиргаа (Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2015).
- “Нутгийн өөрөө удирдах байгууллага болон шийдвэр, үйл ажиллагаанд нь захиргааны хэргийн шүүхэд гомдол гаргахаар хуульд тусгайлан заасан байгууллага зэргээс бусад бүх төрийн болон хувийн өмчийн бүх хуулийн этгээдийг хамруулан ойлгож болно” (Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2015).

Шүүх иргэн, хуулийн этгээдээс хуульд заасан үндэслэлд хамаарах нэхэмжлэлийг нотлох баримтын хамт хүлээн авч, үндэслэлтэй гэж үзвэл иргэний хэрэг үүсгэн шалгаж улмаар хуулийн хугацаанд шүүхийн шийдвэр гарч, нэхэмжлэгч, хариуцагчаас анхан шатны шүүхийн шийдвэрт давж заалдаагүй, гомдол гаргаагүй бол шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болоход шүүх дэх иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дуусгавар болно. Хэрвээ анхан шатны шүүхийн шийдвэрт нэхэмжлэгч, хариуцагчаас давж заалдах, хяналтын журмаар гомдол гаргавал эцсийн шийдвэр гарснаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дуусдаг. Тухайлбал,

“Иргэний хэрэг хянан шийдвэрлэх хугацааг “Хуулиар өөр хугацаа тогтоогоогүй бол хэрэг үүсгэсэн өдрөөс хойш 60 хоног, давж заалдах болон хяналтын шатны шүүхээс хэргийг дахин хэлэлцүүлэхээр ирүүлсэн бол шүүгч хэргийг хүлээж авснаас хойш 30 хоногийн дотор тус тус шийдвэрлэнэ” (Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2002) гэжээ.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд 2024 онд “тусгайлсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа” гэсэн тусгай бүлэг нэмэлтээр орж, энэ зохицуулалт 2024 оны 10-р сараас хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаатай холбогдуулан иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны гомдлыг тухайн хэргийг хянан шийдвэрлэсэн шүүх бус 2025 оны 01-р сараас эхлэн үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн хялбар ажиллагааны шүүх богино хугацаанд хэргийг хянан шийдвэрлэх боломж бүрдсэн. Тухайн тойргийн шүүхэд одоо

батлагдсан хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 20 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний буюу 13.200.000 төгрөгөөс доош үнийн дүнтэй бүх нэхэмжлэлийг хянан шийдвэрлэхээр болсон.

Тусгайлсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх хугацааг ИХШХШ тухай хуулийн 75<sup>2</sup> дугаар зүйлийн 75<sup>2.3</sup> дахь хэсэгт зааснаар “Иргэний хэрэг үүсгэсэн өдрөөс хойш 45 хоног, давж заалдах шатны шүүхээс хэргийг дахин шийдвэрлүүлэхээр буцаасан бол шүүгч хэргийг хүлээж авснаас хойш 14 хоногийн дотор тус тус шийдвэрлэнэ” (Эмхэтгэл, 2002) гэж нарийвчлан зааж, дараах 4 төрлийн нэхэмжлэлд иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа ажиллагаа явуулахаар тогтсон. Үүнд:

1. “Бүх төрлийн гэрээний дагуу мөнгөн хөрөнгө гаргуулах” (Эмхэтгэл, 2002).
2. “Дундын өмчийн ашиглалт, засвар үйлчилгээтэй холбогдсон зардал гаргуулах” (Эмхэтгэл, 2002).
3. “Хөдөлмөрийн гэрээний дагуу цалин хөлс гаргуулах” (Эмхэтгэл, 2002).
4. “Бусдын эд хөрөнгө, эрүүл мэндэд гэм хор учруулсны улмаас мөнгөн хөрөнгө гаргуулах зэрэг нэхэмжлэл хамаардаг” (Эмхэтгэл, 2002).

Иргэний процессын эрх зүй дэх иргэний хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа үргэлжлэх ойлголтыг нэгдүгээрт, иргэний хэргийг шүүхээр эцэслэн хянан шийдвэрлэж, шүүхийн шийдвэр гарч, хуулийн хүчин төгөлдөр болсон, хоёрт, хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрт иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулж шүүхийн шийдвэрийн биелэлтийг хангах, гуравт, хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрт явуулж байгаа шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай холбоотой гомдол буюу нэхэмжлэлийг хянан шийдвэрлэж, шүүхийн шийдвэр гарч, хуулийн хүчин төгөлдөр болсон гэж үзэж болно.

Түүнчлэн хуулийн хүчин төгөлдөр болсон шүүхийн шийдвэрийг хариуцагч сайн дураар биелүүлээгүй, биелүүлэхгүй байгаа нь шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгэх үндэслэл болж иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааг иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаагаар үргэлжлүүлэн явуулах үндэслэл болдог.

Германы эрдэмтэн Вернер Шаллер “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүй” бүтээлдээ “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь заавал иргэний хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны үргэлжлэл болохгүй бөгөөд хэрвээ шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх ёстой хариуцагч этгээд сайн дураараа шийдвэрийг биелүүлсэн тохиолдолд шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа шаардлагагүй болно (Шаллер, 2015, хууд. 15) гэжээ.

Бүх шүүхийн шийдвэр иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явагдахгүй бөгөөд хариуцагч сайн дураар шүүхийн шийдвэрийг биелүүлж байгаа нь иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг дуусгавар болгох үндэслэл болно.

Доктор, профессор А.Лхагваа агсны туурвисан “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүй” бүтээлд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүйг ерөнхий, тусгай ангид ангид хувааж, тусгай ангиа “иргэний хэргийн талаар гарсан шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа” гэсэн нэр томъёог ашиглан бичсэн байдаг.

“Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны үргэлжлэл болсон иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь нэхэмжлэгч буюу төлбөр авагчийн зөрчигдсөн эрхийг сэргээх маш чухал арга хэмжээ бөгөөд төлбөр төлөгчийн шүүхийн шийдвэрийг сайн дураар биелүүлээгүй, биелүүлэхгүй байгаа нь албадан гүйцэтгэх үндэслэл болдог онцлогтой” (ОУ-ын эрх зүйн хөгжлийн байгууллага, 2016, хууд. 51).

“Иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь шийдвэр гүйцэтгэгч, төлбөр авагч, төлбөр төлөгчийн хооронд төлбөрийг биелүүлэхтэй холбоотой эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулагдсан харилцааны нийлбэр байна. Уг ажиллагаанд оролцох субъектийн хувьд нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээд, өмгөөлөгч, төлөөлөгчийн хооронд үүсэж болох харилцаа байдаг (Шүүхийн судалгаа, 2017, хууд. 3) гэжээ.

Мөн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны үргэлжлэл бөгөөд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эцсийн шат, шүүхийн шийдвэр заавал биелэгдэх зарчмын бодит биелэлт болдог онцгой төрлийн иргэний эрх зүйн албадлагын арга хэмжээ юм.

“Монгол Улсын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд иргэний хэргийн шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх журмын талаар нарийвчлан заасан бөгөөд мөн хуулийн 183-188 дугаар зүйлээр зохицуулдаг” (Эмхэтгэл, 2002) Тухайлбал,

1. Процессын хуулиар иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны үндэслэл
2. “Арбитрын шийдвэр, нотариатын мэдэгдэх хуудас, цэргийн анги, байгууллагын захирагч /дарга/-ийн эд хөрөнгийн хариуцлага хүлээлгэх тухай тушаал, Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сангийн зөвлөлийн шийдвэр, захиргааны шийтгэвэр, улсын байцаагчийн төлбөр тогтоосон актын гүйцэтгэлийг шүүхээр баталгаажуулах” (Эмхэтгэл, 2002),
3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх,
4. Шүүхийн шийдвэр болон гүйцэтгэх хуудсыг шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанд албанд шууд гардуулах,
5. Гүйцэтгэх хуудсыг дахин олгох, түүнийг үрэгдүүлсний хариуцлага гэсэн хэсгийг тусгасан байдаг.

Дээрх заалтууд нь иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шүүхийн зүгээс шүүхийн шийдвэр, албадан гүйцэтгэх захирамж, гүйцэтгэх хуудсыг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад хүргүүлснээр иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулж байгаа үйл ажиллагаанд шүүх оролцохгүй байх агуулгыг илэрхийлдэг. Тухайлбал,

Монгол Улсын ИХШХШ тухай хуулийн 183 дугаар зүйлд зааснаар “Шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх үндэслэл шүүхийн шийдвэр болон шүүхээр баталгаажуулсан Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сангийн зөвлөлийн шийдвэр, цэргийн анги, байгууллагын захирагч /дарга/-ийн эд хөрөнгийн хариуцлага хүлээлгэх тухай гушаал, эвлэрлийн гэрээг баталгаажуулсан шүүгчийн захирамж, арбитрын шийдвэр, нотариатын мэдэгдэх хуудас, улсын байцаагчийн төлбөр тогтоосон акт, тэдгээрийн үндсэн дээр олгогдсон гүйцэтгэх хуудас байна” гэжээ.

Мөн хуульд “Шүүхийн шийдвэр, магадлал, тогтоолыг албадан гүйцэтгүүлэхээр шүүгч захирамж гаргах хоёр тохиолдлыг хуульчилсан байдаг. Тухайлбал,

1. “Төлбөр авагч шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгүүлэхээр хүсэлт гаргасан” (Эмхэтгэл, 2002).
2. “Шийдвэрийг даруй биелүүлэх шаардлагатай гэж шүүгч үзсэн бол албадан гүйцэтгэх захирамж гаргадаг” (Эмхэтгэл, 2002).

“Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 186 дугаар зүйлд Шүүхийн шийдвэр болон гүйцэтгэх хуудсыг шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанд шууд олгож болно” (Эмхэтгэл, 2002) гэж заажээ. Үүнд:

1. “Төлбөрийг улсын төсвийн орлогод оруулах” (Эмхэтгэл, 2002).
2. “Төлбөр төлөгч, төлбөр авагчийн аль нэг нь өөр улс, аймаг, сум, дүүрэгт оршин суудаг бол төлбөр авагчийн хүсэлтээр” (Эмхэтгэл, 2002)
3. “Бусдын амь нас, эрүүл мэндэд учирсан гэм хорыг нөхөн төлүүлэх” (Эмхэтгэл, 2002)
4. “Төлбөр авагч шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгүүлэх хүсэлт гаргасан” (Эмхэтгэл, 2002)

Иргэний хэргийн шүүхээс “Шүүхийн шийдвэр болон гүйцэтгэх хуудсыг шууд олгосон тохиолдолд энэ тухай төлбөр авагчид мэдэгдэх талаар Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх хуульд тодорхой заасан байдаг.

Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг явуулах талаар хуульд заасан /6/ үндэслэл (Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2017), мөн хуульд заасан ахлах шийдвэр гүйцэтгэгчийн хоёр /2/ шийдвэр, нийт 8 төрлийн шийдвэрт иргэний шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа явуулдаг. Тухайлбал,

1. “Иргэний хэргийн болон эрүүгийн хэргийн хамт шийдвэрлэсэн иргэний нэхэмжлэлийн талаарх шүүхийн шийдвэр” (Эмхэтгэл, 2017).
2. “Хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэсэн шүүгчийн захирамж” (Эмхэтгэл, 2017).
3. “Монгол Улсын олон улсын гэрээнд заасан бол гадаад улсын шүүх, олон улсын шүүх, арбитрын шийдвэр” (Эмхэтгэл, 2017).
4. Шүүхээр баталгаажуулсан цэргийн анги, байгууллагын захирагч /дарга/-ийн эд хөрөнгийн хариуцлага хүлээлгэх тухай тушаал, нотариатчийн мэдэгдэх хуудас, арбитрын шийдвэр,
5. Шүүхээр баталгаажуулсан гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сангийн зөвлөлийн шийдвэр,
6. “Шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээ авах тухай шүүгчийн захирамж” (Эмхэтгэл, 2017).
7. “Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардал нөхөн төлүүлэх тухай ахлах шийдвэр гүйцэтгэгчийн шийдвэр” (Эмхэтгэл, 2017).
8. Өмчлөх эрх шилжүүлэх тухай дуудлага худалдааны эрхлэн хөтлөгчийн шийдвэр

Дээрх шийдвэрт иргэний шийдвэр гүйцэтгэлийг баталгаажуулах арга хэмжээг хэрэглэж байгаагаас шүүгчийн гүйцэтгэх хуудас, албадан гүйцэтгэх захирамжгүй хэрэгждэг онцгой арга хэмжээ бол “шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээ авах тухай шүүгчийн захирамж, /арбитрын шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах авах арга хэмжээ/ Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардал нөхөн төлүүлэх тухай ахлах шийдвэр гүйцэтгэгчийн шийдвэр” (Эмхэтгэл, 2017), Өмчлөх эрх шилжүүлэх тухай дуудлага худалдааны эрхлэн хөтлөгчийн шийдвэр зэрэг 3 төрлийн шийдвэр хамаарна.

Ямар ч тохиолдолд гүйцэтгэх баримт бичиггүйгээр шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явагдах боломжгүй ба зөвхөн шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээг биелүүлэх иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад гүйцэтгэх хуудас шаардахгүйгээр иргэний шийдвэр гүйцэтгэлийг баталгаажуулах арга хэмжээ явуулдаг.

“Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3 дахь хэсэгт “Хуулийн хүчин төгөлдөр болсон иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг үүсгэх тухай тогтоолын талаар шүүхэд гомдол гаргахгүй” (Эмхэтгэл, 2017) гэж заажээ. Чухамдаа ахлах шийдвэр гүйцэтгэгчийн гаргасан тогтоолын талаар шүүхэд гомдол гаргах эрх хэнд ч байдаггүй онцлогтой.

“Гүйцэтгэх баримт бичиг үрэгдсэн тохиолдолд уг гүйцэтгэх баримт бичгийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журмын

дагуу олгодог боловч үрэгдүүлсэн этгээдэд хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг байна” (Эмхэтгэл, 2002).

Доктор, профессор А.Лхагваа агсан “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хууль тогтоомжид заасан журмын дагуу явуулахад шийдвэр гүйцэтгэгчээс мэдлэг боловсрол төдийгүй өндөр хариуцлага, нягт нямбай ажиллагаа, тооцоо судалгаа шаардагддаг. Үүний нэг нь шийдвэр гүйцэтгэгч шийдвэр гүйцэтгэх бүх ажиллагааны явцад тэмдэглэл хөтлөх явдал юм” (А.Лхагваа, 2024, хууд. 141) гэж бичжээ.

Судлаач Ч.Өнөрцэцэг бүтээлдээ “Иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд эд хөрөнгө, мөнгө гаргуулах, тодорхой үүрэг гүйцэтгэх эсхүл гүйцэтгэхгүй байхыг даалгах, орон сууц, байшин, барилга, байгууламж, агуулах сав, газар чөлөөлөх, нураах, хүүхэд гаргуулах, шилжүүлэх, хүүхэд уулзуулах, хүүхдийн тэтгэлэг гаргуулах, ажилд эгүүлэн томилох, төлбөр авагчийг барилгах байшинд оруулах албадлагын арга хэмжээ хамаарна” (Ч.Өнөрцэцэг, 2022, хууд. 7) гэжээ.

Иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг Монгол Улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1 дэх хэсэгт “Иргэний хэргийн талаарх шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа цаашид иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаа гэж зааж өгөөд иргэний хэргийн шүүхээс гарсан бүх шийдвэрийг албадан гүйцэтгэж болохоор хуульчилсан байдаг.

Монгол Улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 2 дугаар хэсгийг “Иргэний хэргийн талаарх шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа” гэж тодорхойлоод, \ 2-13 дугаар бүлгийн хүрээнд тусгайлан зохицуулсан. Тухайлбал,

- “Мөн хуулийн 2-р бүлгийг “Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаа үүсгэх, нэгтгэх, түдгэлзүүлэх, дуусгавар болгох” гэж нэрлээд 18-31 дугаар зүйлээр” (Эмхэтгэл, 2017),
- Мөн хуулийн 3-р бүлгийг “Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны оролцогч” гэж нэрлээд 32-43 дугаар зүйлээр,
- Мөн хуулийн 4-р бүлгийг “Иргэний шийдвэр гүйцэтгэлийг баталгаажуулах” гэж нэрлээд 44-61 дүгээр зүйлээр,
- Мөн хуулийн 5-р бүлгийг “Хөрөнгө албадан худалдан борлуулах” гэж нэрлээд 62-75 дугаар зүйлээр,
- “Мөн хуулийн 6-р бүлгийг “Төлбөр төлөгчийн хөрөнгөөс суутгал хийх, төлбөрийг төлбөр авагчид шилжүүлэх” гэж нэрлээд 76-85 дугаар зүйлээр” (Эмхэтгэл, 2017),
- Мөн хуулийн 7-р бүлгийг “Төлбөр төлөгч-иргэнээс төлбөр гаргуулах” гэж нэрлээд 86-92 дугаар зүйлээр,

- “Мөн хуулийн 8-р бүлгийг “Төлбөр төлөгч-хуулийн этгээдийн хөрөнгөөс төлбөр гаргуулах” гэж нэрлээд 93-98 дугаар зүйлээр” (Эмхэтгэл, 2017),
- Мөн хуулийн 9-р бүлгийг “Эдийн бус шаардлагыг хангах иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаа” гэж нэрлээд 99-103 дугаар зүйлээр,
- “Мөн хуулийн 10-р бүлгийг “Төлбөрт гаргуулсан мөнгөн хөрөнгийг хуваарилах, төлбөр авагчийн шаардлагыг хангах” гэж нэрлээд 104-114 дүгээр зүйлээр” (Эмхэтгэл, 2017),
- “Мөн хуулийн 11-р бүлгийг “Тадаадын иргэн, харьяалалгүй хүн, гадаад улсын болон олон улсын байгууллагатай холбоотой иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаа” гэж нэрлээд 115-117 дугаар зүйлээр” (Эмхэтгэл, 2017),
- Мөн хуулийн 12-р бүлэгт “Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардал, гүйцэтгэсэн шийдвэрийг цуцлах” гэж нэрлээд 118-119 дүгээр зүйлээр,
- Мөн хуулийн 13-р бүлэгт “Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талуудын болон бусад оролцогчийн эрхийг хамгаалах” гэж нэрлээд 120-122 дугаар зүйлээр хязгаарласан байдаг.

Монгол Улсын хэмжээнд иргэн, захиргааны шийдвэр гүйцэтгэх ажиллагааг бүхэлд нь, харин зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанаас зарим шийтгэл, албадлагын арга хэмжээг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Шийдвэр гүйцэтгэх алба хариуцан аймаг, нийслэл, сум, алслагдсан дүүргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтсийг мэргэжил, арга зүйн удирдлагаар ханган ажиллаж, шүүхийн шийдвэрийн бодит биелэлтийг хангах арга хэмжээ авч ажиллаж байна.

Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар нь 2025 оны 01.10-ны өдрийн байдлаар улсын хэмжээнд зөвхөн төлбөр гаргуулах 3,345,489,763,000 /гурван их наяд, гурван зуун дөчин таван тэрбум давсан/ төгрөгийн 15,789 гүйцэтгэх баримт бичиг байснаас тухайн сарын мэдээгээр 76,537,138,000 /далан зургаан тэрбум давсан/ төгрөгийн 1147 гүйцэтгэх баримт бичгийг дуусгавар болгож, 3,262,569,217,000 төгрөгийн 14,541 төгрөгийн гүйцэтгэх баримт бичгийн үлдэгдэлтэй байна (НШШГГ-ын Тоо бүртгэлийн хэлтэс, 2024).

### ДҮГНЭЛТ:

Иргэний эрх зүйн харилцаанд оролцогч этгээдүүдийн эдийн болон эдийн бус баялагтай холбоотой үүссэн эрх зүйн маргааныг шүүх шийдвэрлэж, шүүхээс гарсан шийдвэр бүр заавал биелэгдэх шинжийг агуулдаг. Гэвч хуулийн хүчин төгөлдөр болсон шүүхийн шийдвэрийг сайн дураар биелүүлэхийг хүсдэггүй этгээдүүдийн дийлэнх олонх нь хариуцагч нар байдаг.

Шүүхийн шийдвэрийг сайн дураар биелүүлэхгүй байгаа хариуцагчийн үйлдэлд төрөөс иргэний эрх зүйн албадлага буюу албадан гүйцэтгэх ажиллагаа явуулж шүүхийн шийдвэрийн бодит биелэлтийг хангахад анхаарч ажилладаг. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа, уг ажиллагааны үргэлжлэл болсон иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн зохицуулалт манай улсад тодорхой түвшинд хөгжсөн байна.

### АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

1. А.Лхагваа. (2024). *Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүй /профессорын эрдмийн дээжис/. УБ.*
2. НШШГГ-ын Тоо бүртгэлийн хэлтэс. (2024). *Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар нь Нийслэл Улаанбаатар хотын Чингэлтэй, Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан, Баянзүрх, Сүхбаатар/ төвийн 6 дүүргийн хэмжээнд шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулдаг бөгөөд улсын мэдээ тухайн жилийн 12 дугаар. УБ.*
3. О.Амархүү. (2018). *Эрх зүйн онол. УБ.*
4. О.Отгонтуяа, & О.Амарсанаа. (2022). *Иргэний эрх зүй. УБ.*
5. ОУ-ын эрх зүйн хөгжлийн байгууллага. (2016). *Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг боловсронгуй болгох-чадавхыг бэхжүүлэх төсөл. Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа гарын авлага. УБ.*
6. С.Нарангэрэл. (2021). *Монгол Улсын Хууль зүйн нэвтэрхий толь бичиг. УБ.*
7. Төрийн мэдээлэл эмхэтгэл. (2002). *Монгол Улсын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1 дэх хэсэгт. УБ.*
8. Төрийн мэдээлэл эмхэтгэл. (2015). *Монгол Улсын Захиргааны ерөнхий хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг. УБ.*
9. Төрийн мэдээлэл эмхэтгэл. (2017). *Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэг. УБ.*
10. Ч.Өнөрцэцэг. (2022). *Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны дараалал, эрх зүйн зохицуулалт. УБ.*
11. Шаллер, В. (2015). *Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүй. УБ.*
12. Шүүхийн судалгаа, м. с. (2017). *Хүчин төгөлдөр болсон шүүхийн шийдвэрийг биелүүлэх тухай лавлагаа. УБ.*
13. эмхэтгэл, Т. м. (2002). *Монгол Улсын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг. УБ.*